

РЕКЛАМНЫ УРИА ҮГЭН ДЭХ ХЭЛЗҮЙН ЗАРИМ ОНЦЛОГ ШИНЖ
(МОНГОЛ, АНГЛИ ЖИШЭЭН ДЭЭР)

Ш.Сэрчмаа*

* "Улаанбаатар" дээд сургуулийн багш, докторант

Түлхүүр үг: реклам, уриа үг, хэл зүйн онцлог, өгүүлбэр зүйн бүтэц, хэлц үг.

Манай оронд сүүлийн арваад жилээс реклам, зар сурталчилгаа эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд рекламны үг хэллэг нь бидний өдөр тутмын амьдралд нөлөө үзүүлсээр байна. Рекламны үг хэллэг нь олон зүйлээр илэрдэг бөгөөд эндээс уриа үгний талаар толилуулъя.

Рекламны харилцаа талаас авч үзвэл уриа нь байгууллага, компанийн мөн чанар, гүн ухааны хураангуй үгс юм. Тухайлбал тухайн байгууллага, компани хэдэн арав, магадгүй зуун бүтээгдэхүүн үйлдвэрлэх боловч тэр бүхний рекламанд нэг л уриа байна.

Өөрөөр хэлбэл бүтээгдэхүүн бүрийн рекламны гарчиг өөр байх боловч уриа нь нэг л байна гэсэн үг юм. Уриа нь товч тогтооход хялбар, худалдааны тэмдэгтийг агуулсан, үл өөрчлөгдөх,

бусад хэл дээр шууд орчуулагдах зэрэг шаардлагад нийцсэн байх шаардлагатай байдаг.

Уриа нь хэн нэгний өвөрмөц байдал, ашиг, зах зээл дэх байр суурь болон амлалтын нийлбэр цогц юм. Хамгийн гол нь таны уриа товч, тодорхой байх нь, таны хир ухаалгийг гаргах бөгөөд хэрэв энэ хоёрыг хослуулж чадвал шилдэг уриа болж чадна гэж судлаачид үздэг байна.

Монгол, англи хэлэн дээр рекламны уриа үг хэрхэн илэрч байгааг хэлзүйн түвшинд авч зарим нэг онцлог шинжийг тодорхойлох оролдлого хийе. Нийт англи, монгол хэлний 1600 гаруй жишээн дээр хийсэн харьцуулсан судалгаанаас толилуулбал:

1. Өгүүлбэрзүйн түвшинд:

1.1. Судалгааны байдлаас харахад англи хэлэнд төгс бус өгүүлбэр (elliptical sentence) рекламны уриа үгэнд нилээд элбэг тохиолдож байна.

Энэ нь монгол хэлэнд ч мөн адил хамгийн их тохиолдож байгаа нь англи хэлний ч нөлөө байж болох юм.

• All the biggest stories (a new magazine)

Монгол хэлэнд

• Амттан бүхэн миний өмнө (Атар өргөө ХК)

• Бүгдийг нэг дороос

(Компьютерийн BSB).

1.2. Өгүүлэхүүн

нь нэр үгээр илэрсэн, нэршсэн өгүүлбэр монгол рекламны уриа үгэнд элбэг тохиолдож байна. Жишээлбэл:

• Амьдралын шинэ чанар ОХУ-ын гурил Алейка. (Алейка).

• Кредит банк та бидний итгэлцэл (Кредит банк)

Англи хэлний жишээ:

• A perfect pairing. A perfect film. (for a new film)

1.3. Энгийн богино өгүүлбэр хэрэглэх.

Уриа нь энгийн, богино байх нь тогтооход хялбар байдаг. Зар сурталчилгааны уриа үгний гол зорилго нь амархан цээжлэгдэж, тогтоогддог байх ёстой. Иймээс энгийн богино өгүүлбэрүүд зар сурталчилгааны уриа үгэнд хамгийн тохиромжтой байдаг. Энэ байдал ч англи, монгол хэлний рекламны үг хэллэгэнд түгээмэл байна. Жишээлбэл:

• Everyone is invited. (Samsung Digital)

• We bring good things to life. (GE)

Монгол хэлэнд:

• Шинэ загварын бараа ирлээ. (Nomin дэлгүүр)

• Зээлийн хүү буурлаа. (Голомт банк)

1.4. Судалгааны байдлаас харахад

хавсарсан нийлмэл, угсарсан нийлмэл, холимог нийлмэл өгүүлбэрүүд цөөн тохиолдолд байхад харин зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрүүд цөөнгүй хувийг эзэлж байна. Жишээлбэл:

• Хамтарч ажиллая, хамтдаа хөгжье! (Азийн Алтан Сан ХЗХ)

• Та бидэнд итгэ, бид бүгдийг хийе! (Жигүүр Гранд ХХК)

Англи хэлэнд:

• Life is too short and winter is too long. Not necessary. (for milk)

• Your pension will take off because of what we don't. (for a pension fund)

1.5. Асуух өгүүлбэр хэрэглэх нь

Зар сурталчилгааны уриа үгний өгүүлбэрийг асуултаар илэрхийлэх нь үйлчлүүлэгчдийн анхаарлыг ихээр татдаг. Энэ нь тэдний сониуч занг бий болгодог ба тэдний унших дур сонирхлыг өдөөж өгдөг байна. Англи, монгол

«

Өөрөөр хэлбэл бүтээгдэхүүн бүрийн рекламны гарчиг өөр байх боловч уриа нь нэг л байна гэсэн үг юм. Уриа нь товч тогтооход хялбар, худалдааны тэмдэгийг агуулсан, үл өөрчлөгдөх, бусад хэл дээр шууд орчуулагдах зэрэг шаардлагад нийцсэн байх шаардлагатай байдаг.

»

хэлний олонх урианууд асуух өгүүлбэрээр илэрсэн байгааг эдгээр жишээнээс харж болно. Жишээлбэл:

- Have you driven a Ford lately?

(Ford)

- Where do you want to go today?

(Microsoft)

Монгол жишээ:

- Танд хямд үнээр чанартай орон сууц хэрэгтэй байна уу? (ЭКО Констракшн)

- Та машинаа даатгуулсан уу?

(Монгол Даатгал Тээврийн хэрэгслийн даатгал)

1.6. Захирах өгүүлбэр хэрэглэх нь

Зар сурталчилгааны уриа үг нь цөөн хэдэн үгээр илэрхийлэгддэг. Тэд үйлчлүүлэгчдийг ятгаж, уриалах бүхий л аргыг хэрэглэдэг. Урианы гол зорилго нь хамгийн сүүлчийн тулалдааны талбарт хүмүүсийг авчрах явдал юм. Зар сурталчилгаан дахь энэ төрлийн өгүүлбэрүүд нь өөрийнхээ зорилгод хүрэхэд хамгийн тохиромжтой арга юм. Жишээлбэл:

- Don't leave home without it

(Express card)

- United Airlines: Life is a journey, travel it well. (United Airlines)

Монгол хэлэнд:

- Та яарагтун (Цайрт Менерал ХХК)
- Та яг одоо яриад үз (World Call 002 Skytel)

2. Үгсийн сангийн түвшинд

Монгол хэлний рекламны үг хэллэгт ардын аман зохиол ашиглах, утга

шилжүүлэн дүрслэх аргыг сүүлийн үед түгээмэл хэрэглэх болжээ. Үүнд: "Номин" электрон барааны дэлгүүрийн нэгэн рекламанд утга шилжүүлэн дүрслэх аргыг хэрэглэснийг дурдаж болох юм.

Эрхсийн цэнхэр тэнгэр нь Номин

Илбийн цэнхэр зэрэглээ нь Номин

Энхийн цэнхэр хадаг нь Номин

Электрон барааны дэлгүүр нь

Номин

Миний эх орон номин эрдэнийн

билээ.

3. Хэлц үгийг хэрэглэсэн байдал

Хэлц нь товч хураангуй байдаг. Энэ нь англи хэлний зар сурталчилгааны уриа үг хэллэгт элбэг байна. Жишээлбэл:

- Think different (Apple computer)
- Beyond expectation (Malaysia Airlines)

4. Хоёрдогч этгээдэд хандсан "та", "бид", "биднийг" гэсэн төлөөний нэрийг хэрэглэх

"Та", "Таны" гэсэн үгийг хэрэглэснээр бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, хэрэглэгч хоорондын зайг ойртуулж өгдөг. Энэ нь үйлдвэрлэгч, эсвэл сурталчилгаа нь хэрэглэгчтэй нүүр тулан, ямар нэгэн зүйл санал болгож байвал уриа нь хэрэглэгчдэд илүү хурдан хүрэх боломжтой гэж үздэг. Үүнийг хүлээн авагч нь өөрт ямар их анхаарал хандуулж, анхаарлын төвд байгаагаа мэдрэх болно. Жишээлбэл:

- Always there for you (HYUNDAI)
- Bring out the champion in you.

(Nestle Milo)

Монгол хэлэнд ч энэ байдал түгээмэл байна. Доорхи жишээнээс харвал:

- Та ирээд үз, мэдрэх болно

(Чингис клуб)

• ӨГӨӨЖ - ӨДӨР БҮР ТАНТАЙ ХАМТ! (Өгөөж ХК)

Бид, биднийг гэж хандах нь тухайн урианы үндсэн санаа, үзэл, үнэлгээг хүлээн авагчдад шууд илэрхийлэх явдал юм. Энэ нь өөрийгөө бусдад таниулах, ойлгуулах, итгүүлэх арга зам юм. Жишээлбэл:

- We try harder (Avis rent a car)
- We live to deliver (Fed Ex)

Энэ нь мөнхүү монгол хэлний жишээн дээр ижил хэрэглэгдэж байна.

- Та бидэнд итгэ, бид бүгдийг хийе (Жигүүр Гранд ХХК)

- Амьдралын тохилог орчныг бид бүрдүүлнэ. (Хөгжил Хотхон)

Судалгааны байдлаас үзэхэд англи, монгол хэлний рекламны уриа үгэнд:

1. Нэршсэн богино өгүүлбэр, хэлцүүд түгээмэл хэрэглэгдэж байгаа нь нийтлэг байна.

2. ХНӨ, ХоНӨ, УНӨ-ийг төдийлэн хүмүүс тогтож уншдаггүй, тогтооход

хялбар биш байдаг учраас рекламны уриа үгэнд түгээмэл хэрэглэгддэггүй гэсэн дүгнэлт хийж байна.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Бадамдорж Д. 2001. Монгол хэлний утга судлал. УБ.
2. Дэмбэрэл С. 2000. Зар сурталчилгаа ба түүний маркетинг. УБ.
3. Лувсанвандан Ш. Монгол хэлний үг зүйн байгуулалт. УБ.
4. Саранцацрал Ц. 2001. Монгол хэлний хамтран үйлдэх хэлэхүйн үйлдэл, түүний прагматик, семантик хэлзүйн онцлогууд. ХУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. УБ.
5. Чулуундорж Б. 2002. Төрөл бус хэлний энгийн өгүүлбэрийг утгазүйн хэв шинжээр зэрэгцүүлсэн судалгаа. УБ.

Abstract

In the advertising language, there appear several features both in lexical and syntactic fields. In the syntax of advertising texts there occur compound and simple sentences. The interrogative and negative sentences don't occur as much. Comparatives and superlatives occur in almost every advertisement, often combined with the adjectives giving positive information about the advertised item.